

**ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛАГДСАН ИНД-43-ЫН ХАРЬЦУУЛАЛТ**

<p align="center"><b>Техник үйлчилгээний ерөнхий дүрэм</b> (Шинэчлэгдэж байгаа) / 36 хуудас/ 2017 оны NZ amend.14/</p>	<p align="center"><b>ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ДҮРЭМ /</b> <b>GENERAL MAINTENANCE RULES</b> (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) /25 хуудас (үндсэн дүрэм-64 хуудастай байсан)/ 1997 оны NZ amend.3</p>	<p align="center"><b>Тайлбар</b></p>
<p><b>А Бүлэг-Ерөнхий зүйл</b></p>	<p><b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ/GENERAL</b></p>	
<p><b>43.1. Зорилго</b></p> <p>(a) Энэ Дүрэм нь, энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:</p> <p>(1)ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн техник үйлчилгээ хийх;</p> <p>(2)ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;</p> <p>(3)ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлөгт суурилуулах бүрдэл хэсгийн техник үйлчилгээ болон техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;</p> <p>(4)<a href="#">бусад холбогдох үйл ажиллагааны дүрэмтэй хамааралтай ИНД-91-ээр шаардсан агаарын хөлөгт суурилуулах хэрэглэл болон төхөөрөмжийн техник үйлчилгээ болон техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;</a></p> <p>(5)НТЧ-ын жилийн үнэлгээний.</p> <p>(b) <a href="#">Техникийн зохицуулалтад өөрөөр заагаагүй бол Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт, эсхүл Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт суурилуулахаар төлөвлөж байгаа бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд, хэрэв тухайн техник үйлчилгээг дараах байдлаар хийх бол В болон С Бүлгийн шаардлага хамаарахгүй:</a></p> <p>(1) <a href="#">техникийн зохицуулалтын оролцогч тал болох, өөр улсад;</a></p> <p>(2) <a href="#">энэ зүйлийн (b)(1)-д заасан улсаас олгосон ТҮБ-ын гэрчилгээ, эсхүл зөвшөөрлийн хүрээнд, тухайн улсын хяналтад;</a></p> <p>(3) <a href="#">энэ зүйлийн (b)(2)-т заасан ТҮБ-ын эрх болон</a></p>	<p><b>43.1. Зорилго/Purpose</b></p> <p>(a) Энэ дүрмээр дараах үйл ажиллагааг зохицуулна:</p> <p>1/ ИНД-21-ийн дагуу Нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсэгт ИНД-91-д шаардсаны дагуу хийгдэх техник үйлчилгээ (цаашид ТҮ гэх);</p> <p>2/ ИНД-21-ийн дагуу НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн хэсгийг ИНД-91-д шаардсаны дагуу ТҮ-нээс гаргах;</p> <p>3/ ИНД-21-ийн дагуу НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөгт суурилагдсан эд анги, тоног төхөөрөмжид ИНД-91-д шаардсаны дагуу ТҮ гүйцэтгэх, тэдгээрийг ТҮ-нээс гаргах;</p> <p>4/ НТЧ-ын жилийн үзлэг хийх.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.5-аар өөрчлөгдсөн</p>

<p><u>холбогдох журмын дагуу;</u></p> <p>(4) <u>тухайн техникийн зохицуулалтад өөрөөр заагаагүй бол, энэ зүйлийн (b)(1)-д заасан улсын холбогдох техник үйлчилгээний стандарт болон журмын дагуу;</u></p> <p>(5) <u>тухайн техникийн зохицуулалтад заасан нөхцөлийн дагуу.</u></p>		
<p><b>43.3. Тодорхойлолт ба товчлол</b> Энэ Дүрэмтэй холбоотой нэр томъёо болон товчлол нь ИНД-ийн нэр томъёоны тайлбарт багтсан.</p>		Нэр томъёоны тайлбар ИНД-1-д орсон
<p><b>43.5. Техник үйлчилгээний баримт бичгийг хуурамчаар үйлдэх, нөхөн үйлдэх, эсхүл өөрчилж засварлах</b> Аливаа этгээдийг дараах үйлдлийг хийх, эсхүл хийх шалтгааныг бий болгохыг хориглоно:</p> <p>(1) энэ Дүрмийн шаардлагын хэрэгжүүлэлтийг харуулахад хэрэглэдэг, эсхүл хадгалдаг болон хийдэг байхыг шаардсан бүртгэл, эсхүл тайланд хуурамч, эсхүл санаатай худал мэдээлэл оруулах; эсхүл</p> <p>(2) энэ Дүрмийн хүрээнд үйлдсэн бүртгэл, эсхүл тайланг хууран мэхлэх зорилгоор нөхөн үйлдэх, эсхүл өөрчилж засварлах.</p>		Орхигдуулсан зүйлийг нэмж оруулсан.
<p><b>В Бүлэг — Техник үйлчилгээ</b></p>	<p><b>Б БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ / MAINTENANCE</b></p>	
<p><b>43.51. Техник <u>үйлчилгээ хийх этгээд</u></b></p> <p>(a) Энэ зүйлийн (b) болон (d)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (e) болон <u>43.54</u>-ийг харгалзан, дараах шаардлагыг хангаагүй этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийхийг хориглоно:</p> <p>(1) ИНД-66-гийн дагуу олгосон, тохирох категори болон зэрэглэл бүхий AMEL-ийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг байх; эсхүл</p> <p>(2) ИНД-145-ын дагуу олгосон, тохирох ангилалтай Агаарын хөлгийн ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс тухайн техник үйлчилгээ хийхээр зөвшөөрөгдсөн байх; эсхүл</p> <p>(3) ИНД-66-гийн дагуу олгосон, зохих баталгаажуулсан тэмдэглэл хийсэн хүчинтэй MAC эзэмшдэг байх; эсхүл</p>	<p><b>43.51. Техник <u>үйлчилгээг гүйцэтгэх зөвшөөрөл</u></b> <b>Persons to perform maintenance</b></p> <p>(a) Энэ зүйлийн (б), (в)-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан инженер техникийн ажилтанд агаарын хөлөг, түүний эд ангид ТҮ хийх зөвшөөрөл олгоно:</p> <p>1/ ИНД-66-гийн дагуу олгогдсон агаарын хөлгийн техник үйлчилгээний <b>ажилтны</b> мэргэжлийн үнэмлэх, холбогдох маягийн зэрэглэлтэй; эсхүл</p> <p>2/ <b>Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны мэргэжлийн үнэмлэх болон холбогдох маягийн зэрэглэл нь Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-аар хүлээн зөвшөөрөгдсөн; эсхүл</b></p> <p>3/ ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн байгууллагаас ТҮ гүйцэтгэх зөвшөөрөл олгосон; эсхүл</p> <p>4/ ТҮ-г дараах этгээдийн шууд хяналтанд гүйцэтгэх бол:</p> <p>4.1 ИНД-66-ын дагуу, агаарын хөлгийн ТҮ-ний ажилтны мэргэжлийн үнэмлэх, холбогдох</p>	-Орчуулга, найруулга зассан

(4) Монгол Улсын гадна хийгдэх техник үйлчилгээний хувьд, ИCAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрхийн хүрээнд олгосон, тухайн агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгт хүчинтэй AMEL, эсхүл MAC эзэмшдэг байх; эсхүл

(5) энэ зүйлийн (a)(1), (3), (4), эсхүл (5)-д заасан тохирох этгээдийн шууд хяналтад тухайн техник үйлчилгээг хийдэг байх.

(b)Энэ зүйлийн (c)-г харгалзан, энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг хангаагүй боловч дараах аль нэг үнэмлэх эзэмшдэг этгээд нь Хавсралт А.1-д заасан техник үйлчилгээг ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөгт, эсхүл Хавсралт А.1 болон А.2-т заасан техник үйлчилгээг арилжааны нислэгийн үйл ажиллагаанд ашигладаггүй агаарын хөлөгт хийж болно:

(1) ИНД-61-ийн дагуу олгосон, тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчинтэй нисгэгчийн үнэмлэх;

(2) ИНД-66-гийн дагуу олгосон, хүчинтэй AMEL;

(c)Энэ зүйлийн (b)-д заасан этгээд нь:

(1) ИНД-66-гийн дагуу олгосон, тохирох зэрэглэл бүхий хүчинтэй AMEL эзэмшигчийн сургалтад зохих ёсоор хамрагдсан ба агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч техник үйлчилгээ хийхийг бичгээр зөвшөөрсөн байх; эсхүл

(2) энэ Дүрэм, эсхүл ИНД-121, 125, эсхүл 135-д шаардсан, ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд техник үйлчилгээ хийгдэх агаарын хөлгийн хувьд, тухайн агаарын хөлгийн маягт техник үйлчилгээ хийхээр зохих ёсоор сургалтад хамрагдсан ба ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс олгосон тохирох эрх эзэмшдэг байх үүрэгтэй.

(d)Энэ зүйлийн (a)-ийн шаардлагыг хангаагүй этгээд нь, хэрэв дараах шаардлагыг хангасан бол глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийж болно:

(1) глайдерын байгууллагаас олгосон глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх

маягийн зэрэглэлтэй этгээд, эсхүл  
4.2 ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн байгууллагаас зөвшөөрөл олгогдсон этгээд.

(б) ИНД-61-ийн дагуу нисэгчийн үнэмлэх, холбогдох маягийн зэрэглэл эзэмшигч нь дараах тохиолдолд энэ дүрмийн Хавсралт А-д заасан ТҮ-г гүйцэтгэнэ:  
1/ холбогдох сургалтанд хамрагдсан;

2/ агаарын хөлгийг эзэмшигч, эсвэл ашиглагчийн эрхтэй бол.

(в) Планер, түүний бүрэлдэхүүн эд анги, тоног төхөөрөмжид ТҮ хийх этгээд нь:

1/ ИНД-149-ийн дагуу нисэх клубын гэрчилгээ эзэмшигч байна; эсхүл

Amend.7-оор (5),(6),(a)-гийн (1),(2)-р нэмэгдсэн

-“Планер” гэснийг “Глайдер” гэж

<p>зөвшөөрөлтэй байх; эсхүл</p> <p>(2) <u>тухайн техник үйлчилгээг глайдерын</u> байгууллагаас олгосон <u>глайдер</u>, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх эрх бүхий этгээдийн шууд хяналтад хийх.</p> <p><u>(е)ИНД-47.55(с)-д шаардсан агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд нэр заагдсан техник үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчийн сургалтад зохих ёсоор хамрагдаж, зөвшөөрөгдсөн байхаас бусад тохиолдолд аливаа этгээдийг тусгай категорин-үзүүлбэрийн НТЧ-ын гэрчилгээ, эсхүл тусгай категорин-хязгаарлагдмал НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт техник үйлчилгээ хийхийг хориглоно.</u></p>	<p>2/ ИНД-149-ийн дагуу нисэх клубын гэрчилгээ эзэмшигчийн шууд хяналтанд ТҮ-г гүйцэтгэнэ.</p>	<p>-Amend.7-оор нэмэгдсэн.</p>
<p><b>43.53. Техник үйлчилгээний гүйцэтгэл</b></p> <p>Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд нь дараах үүрэгтэй:</p> <p>(1) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн НТЧ-ын хадгалалтад шаардлагатай техник үйлчилгээний ажлын талаар зохих мэдлэгтэй байх;</p> <p>(2) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн задаргаа, үзлэг шалгалт угсралт хийхэд тохиромжтой ажлын байр болон <u>байгууламжийг ашиглах</u>;</p> <p>(3) дараах аргачлалыг ашиглах:</p> <p>(i) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн НТЧ-ын хадгалалтын зааварчилгаанд заасан арга, техник болон практик аргачлалыг; эсхүл</p> <p>(ii) <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх арга, техник болон практик аргачлалыг;</p> <p>(4) материал, эд анги болон хэрэгслийг ИНД-21-ийн К Бүлгийн шаардлагын дагуу ашиглах;</p> <p>(5) энэ зүйлийн (3)-т заасны дагуу ажлын гүйцэтгэлийг бататгахад шаардлагатай багаж, төхөөрөмж болон тестийн төхөөрөмжийг ашиглах;</p> <p>(6) тухайн тест хийгдэж байгаа бүрдэл хэсэг нь нислэгт тэнцэх нөхцөлд байгааг бататгах зорилгоор, үйлдвэрлэгчийн зөвлөсөн тестийн төхөөрөмжийг, эсхүл тест хийж байгаа этгээдэд ижил боломжийг олгох, дүйцэх тестийн төхөөрөмж ашиглах;</p> <p>(7) хэрэв техник үйлчилгээний журамд заасан бол, үйлдвэрлэгчийн зөвлөсөн тусгай тестийн төхөөрөмж, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх тестийн</p>	<p><b>43.53. Техник үйлчилгээг гүйцэтгэх /Performance of maintenance</b></p> <p>(a) Агаарын хөлөг, түүний эд ангид ТҮ гүйцэтгэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>1/ агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалтыг хангахад шаардлагатай ТҮ-ний үйл ажиллагаа болон агаарын хөлгийн бүтэц, систем, тоног төхөөрөмжийн талаар зохих мэдлэгтэй байна;</p> <p>2/ агаарын хөлгийн ТҮ-ний хөтөлбөр, үйлдвэрлэгчийн зааврыг мөрдөж ажиллахад шаардагдах ажлын байр, <u>багаж тоног төхөөрөмжийг бүрдүүлсэн байна</u>;</p> <p>3/ НТЧ-ын хадгалалтын зааварчилга, үйлдвэрлэгчийн ТҮ-ний заавар, журам, технологийг ашигладаг байна (заавар, түүний нэмэлт өөрчлөлтийг <u>ИНЕГ</u>-ын дарга хүлээн зөвшөөрсөн байна);</p> <p>4/ ИНД-21-ийн "Ж" Бүлэгт заасны дагуу материал сэлбэг, тоног төхөөрөмжийг ашиглана;</p> <p>5/ энэ зүйлийн (а)-гийн 3/-т заасан зааварт шаардсан шалгах багаж төхөөрөмж ашиглана;</p> <p>6/ үйлдвэрлэгчийн зөвлөсөн тусгай болон шалгах тоног төхөөрөмж, эсхүл түүнтэй адилтгах, ажиллах нөхцөл нь шалгагдаж баталгаажсан тоног төхөөрөмж ашиглана;</p> <p>7/ агаарын хөлөг, түүний эд анги нь НТЧ-ын холбогдох шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг бататган ТҮ-г гүйцэтгэнэ;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-<u>“багаж тоног төхөөрөмж” гэснийг “байгууламж” гэж өөрчилөгдсөн</u></p> <p>-“ИНЕГ-ын дарга” гэснийг “Дарга” гэж</p> <p><b>-Эдгээр шаардлагууд 43.54-р зүйлд туссан</b></p>

төхөөрөмж ашиглах;

- (8) тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн хамааралтай НТЧ-ын бүх шаардлагыг хангаж байгааг бататгах хүртэл техник үйлчилгээг хийх;
- (9) техник үйлчилгээг хийж дуусахад, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн төлөв байдал нь ашиглалтад шилжүүлэх шаардлага хангасан ба эх загварын, эсхүл зохих ёсоор сайжруулалт хийгдсэн нөхцөлтэй тэнцүү, эсхүл түүнээс доошгүй байгааг дараах чиглэлээр бататгах:
- (i) аэродинамикийн ажиллагаа;
  - (ii) бүтцийн бат бэх байдал;
  - (iii) чичиргээ болон элэгдэл гэмтлийг эсэргүүцэх чадвар;
  - (iv) НТЧ-т нөлөөлж байгаа бусад чанар;
- (10) техник үйлчилгээ дуусахад агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь дуу чимээний хязгаарлалт болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангаж байгааг бататгах;
- (11) тухайн этгээд агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээний ажлаас дараах байдлаар чөлөөлөгдөж амарснаас бусад тохиолдолд техник үйлчилгээ хийхгүй байх:
- (i) тухайн техник үйлчилгээг хийхийн өмнөх 24 цагийн хугацаанд үргэлжилсэн 8-аас доошгүй цаг амарсан;
  - (ii) тухайн техник үйлчилгээг хийхийн өмнөх 30 хоногийн хугацаанд үргэлжилсэн 24 цагаас доошгүй хугацаагаар, 4-өөс доошгүй удаа амарсан.

8/ ТҮ-г гүйцэтгэхдээ үйлдвэрлэгчийн ТҮ-ний зааврын "НТЧ-ын хязгаарлалт" гэсэн бүлэг, эсхүл НТЧ-ын хадгалалтыг хангах талаар гарсан зааврыг мөрдөнө;

9/ ТҮ-г ИНД-91 ба ИНД-119-ийн дагуу ИНЕГ-ын эрх бүхий этгээдээр батлагдсан хөтөлбөрийг үндэслэн гүйцэтгэж байгаа бол:

9.1 ТҮ-ний хөтөлбөрийг гүйцэтгэхээс өмнө агаарын хөлөгт бүрэн үзлэг хийнэ;

9.2 анхан шатны үзлэг хийсний дараа хөтөлбөрийн дагуу нарийвчилсан үзлэг хийнэ.

10/ агаарын хөлөг, түүний эд анги НТЧ-ын шаардлага хангасан эсэхийг бататган ТҮ- нээс гаргахдаа түүний техникийн нөхцөл байдал нь тухайн агаарын хөлөг, эд

ангийн анхны хувилбар болон хийгдсэн өөрчлөлт шинэчлэлттэй нийцэж байгаа эсэхийг дараах үзүүлэлтээр тодорхойлно:

10.1 аэродинамик;

10.2 бүтцийн бөх бат байдал;

10.3 чичиргээ болон эвдрэл гэмтлийг эсэргүүцэх чадвар;

10.4 НТЧ-т нөлөөлөх бусад шинж чанар.

11/ техник үйлчилгээний төгсгөлд, агаарын хөлөг, эсхүл түүний бүрэлдэхүүн хэсэг нь дуу чимээний хязгаарлалт болон хөдөлгүүрээс гарах хийн ялгаруулалтад тавигдах гэрчилгээжүүлэлтийн шаардлагуудыг хангасан эсэхийг бататгана;

12/ техник үйлчилгээг гүйцэтгэх, хянах,

баталгаажуулах болон техник үйлчилгээнээс гаргах эрх бүхий этгээдийн ажлын цагийн хязгаарлалтыг доорхи байдлаар тогтоосон журамтай байна. Үүнд:

12.1 үүрэгт ажлаа гүйцэтгэж эхлэхээс өмнөх 24 цагийн хугацаанд үргэлжилсэн 8-аас доошгүй цагт нь амарсан байх;

	12.2 хэрэв ажлын өдрийг 30 хоногоор тооцох бол үргэлжилсэн 24 цагаар 4-өөс доошгүй удаа амарсан байх.	
<p><b>43.54. ИНД-145-ын дагуу хийхийг шаарддаг техник үйлчилгээ</b></p> <p>(a) Хууль болон ИНД-145-ын дагуу Даргын олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнээс бусад тохиолдолд аливаа этгээдийг дараах техник үйлчилгээ хийх, эсхүл ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:</p> <p>(1) хэрэв тухайн агаарын хөлгийг дараах зорилгоор ашигладаг бол МСТOW нь 5700кг-аас дээш жинтэй, эсхүл 10, эсхүл түүнээс дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамжтай агаарын хөлөгт,:</p> <p>(i) Хууль <a href="#">болон ИНД-119</a>-ийн дагуу <a href="#">Даргын</a> олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд арилжааны нислэгийн үйл ажиллагаанд; эсхүл</p> <p>(ii) Хууль болон <a href="#">ИНД-115</a>-ын дагуу <a href="#">Даргын</a> олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд (халуун агаарын бөмбөлгөөс бусад); эсхүл</p> <p>(2) энэ хэсгийн (1)-д заасан агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл суурилуулахаар төлөвлөж байгаа бүрдэл хэсэгт.</p> <p>(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээдийг (Хууль болон ИНД-145-ын дагуу Даргын олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд зааснаас бусад тохиолдолд) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт дараах техник үйлчилгээ хийх, эсхүл тухайн техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:</p> <p>(1) бүрдэл хэсгийн их засвар;</p> <p>(2) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээ хэрэв НТЧ-ын хадгалалтын холбогдох зааварчилгаанд үйлдвэрлэгчийн зөвшөөрсөн, эсхүл баталсан, эсхүл Даргын зөвшөөрсөн хэв (jig) ашиглахыг шаарддаг бол;</p> <p>(3) хэрэв тухайн техник үйлчилгээнд бенч тест хийсэн байдлаар нийлүүлдэг нэгжийн бүрдэл хэсгийн аль нэг хэсгийн задаргаа багтдаг бол, дараахаас бусад тохиолдолд бүрдэл хэсгийн техник үйлчилгээ хэрэв:</p> <p>(i) ашиглалтын явцад солилт, эсхүл тохируулага хийх боломжтой эд ангийн бүрэлдэхүүн хэсгийг солих,</p>	<p>(б) Энэ зүйлийн (г)-д зааснаас бусад тохиолдолд ИНД-145-ын дагуу гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа дараах агаарын хөлөг, эд ангид ТҮ-г гүйцэтгэхгүй ба тэдгээрийг ТҮ-нээс гаргахгүй:</p> <p>1/ үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлөг нь:</p> <p>1.1 хөөрөлтийн хамгийн их жин нь 5700 кг-аас их; эсхүл</p> <p>1.2 нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10 ба түүнээс дээш зорчигчийн суудалтай.</p> <p>2/ энэ зүйлийн (б)-гийн 1/-д дурьдсан агаарын хөлөгт суурилуулах болон суурилагдсан эд анги.</p> <p>(в) Энэ зүйлийн (г)-д зааснаас бусад тохиолдолд ИНД-145-ын дагуу гэрчилгээ эзэмшээгүй аливаа этгээд агаарын хөлөг, түүний бүрэлдэхүүн, эд ангид дараах ТҮ гүйцэтгэхгүй ба тэдгээрийг ТҮ-нээс гаргахыг хориглоно:</p> <p>1/ эд ангийн их засвар;</p> <p>2/ НТЧ-тай холбогдолтой өгөгдөхүүний шаардлагын улмаас үйлдвэрлэгч, эсхүл <a href="#">ИНЕГ</a>-ын даргаар баталгаажсан эталоныг ашиглан агаарын хөлөг, түүний эд ангид гүйцэтгэх ТҮ;</p> <p>3/ дор дурьдсанаас бусад тохиолдолд эд анги, түүний бүрэлдэхүүн хэсэгт лабораторын үзлэг хийх, шаардлагатай дутагдлыг арилгах ТҮ:</p> <p>3.1 эд ангийн дутагдалтай хэсгийг ердийн аргаар солих;</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-“Иргэнийн агаарын тээвэр” гэснийг “Арилжааны тээвэр” гэж</p>

- эсхүл тохируулах зорилгоор задаргаа хийх бол;
- (ii) хэвийн байдлыг нь өөрчилсөн эд ангийн дараагийн үйл ажиллагааг хэвийн ажиллагаа шалгахад ашигладаг тестийн аппарат өөр, нэмэлт тестийн аппаратаас гадна ашиглахгүйгээр шалгаж чадах бол;
- (4) агаарын хөлгийн хөдөлгүүрийн техник үйлчилгээ, хэрэв тухайн техник үйлчилгээнд дараах ажил багтдаг бол:
- (i) цилиндр, эсхүл поршинт иж бүрдэлд нэвтрэх зай гаргах зорилгоор задлах болон угсрахаас бусад, поршинт хөдөлгүүрийг задлах болон угсрах; эсхүл
- (ii) турбинт хөдөлгүүрийн үндсэн гадаргуу (stator) эсхүл үндсэн эргэх иж бүрдлийг задлах болон угсрах хэрэв задаргаа болон угсралт нь үндсэн гадаргуу, эсхүл үндсэн эргэх иж бүрдлийг солих ажил бөгөөд тухайн хөдөлгүүрийн НТЧ-ын хадгалалтын зааварчилгаанд солих зааварчилгаа багтсан ба тухайн хөдөлгүүрийн үндсэн гадаргууг, эсхүл эргэх иж бүрдлийг солих ажил нь үндсэн гадаргуугийн холбоосыг салгаж хийгддэг байхаас бусад тохиолдолд эсхүл;
- (iii) хурдны хайрцагт задаргаа хийх;
- (5) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгааны дагуу хийх сэнсний динамик балансас бусад, сэнсний баланс хийх;
- (6) хэрэв тухайн техник үйлчилгээнд дамжуулах хурдны хайрцгийг задлах ажил багтдаг бол нисдэг тэргэнд хийх техник үйлчилгээ, хэрэв дотор талын үзлэг шалгалт хийх зай гаргах зорилгоор гадаргууг салгахаар задлах тухайн задаргааг үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу хийдэг байхаас бусад тохиолдолд.

- (c) Энэ зүйлийн (b) нь Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлгөөс бусад, дараах агаарын хөлөгт хамаарахгүй:
- (1) Хууль болон ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу Даргын олгосон *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөг; эсхүл
- (2) хэт хөнгөн агаарын хөлөг; эсхүл
- (3) глайдер, эсхүл моторт-глайдер; эсхүл
- (4) халуун агаарын бөмбөлөг.

3.2 шалгах багаж хэрэгсэлгүйгээр ажиллагааг шалгах үед дутагдал нь илэрхий мэдэгдэж байх.

4/ агаарын хөлгийн хөдөлгүүрт хийх дараах ТҮ:

4.1 цилиндр болон бүлүүрийн хэсэгт үзлэг хийхээс бусад тохиолдолд поршинт хөдөлгүүрийг задлах, угсрах; эсхүл

4.2 хөдөлгүүрийн ашиглалтын зааврын дагуу үндсэн бүрээс их биений холбоосоор салган үндсэн эргэх эд анги болон бүрээс их биеийг солих ажиллагаанаас бусад тохиолдолд турбинт хөдөлгүүрийн үндсэн эргэх хэсэг, эсхүл үндсэн бүрээс их биеийг задлах угсрах; эсхүл

4.3 редукторын гэмтэл дутагдлыг засах.

5/ тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу сэнсний динамик тэнцвэржүүлэлт хийхээс өөрөөр тэнцвэржүүлэлт хийх ТҮ;

6/ үйлдвэрлэгчээс гаргасан ТҮ-ний зааврын дагуу дотор талын үзлэг хийх зорилгоор задлахаас бусад тохиолдолд нисдэг тэргэний дамжуулах редукторын аливаа эд ангийг задлах ТҮ.

(г) Энэ зүйлийн (б), (в) хэсэг нь тусгай ангиллын НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөг, эсхүл хөнгөн агаарын хөлөг, планер, хөдөлгүүрт планер, агаарын бөмбөлөгт хамаарахгүй.

**43.55. Их засварын бүртгэл хөтлөх**

ИНД-д шаардсан агаарын хөлөг, хүчилсэн бүтэц, хөдөлгүүр,

**43.55. Их засварын бүртгэл / Recording of overhaul**

(a) Дараах ажиллагаа хийгдээгүй тохиолдолд аливаа

-Орчуулга найруулга зассан

<p>сэнс, эсхүл агаарын хөлгийн бусад бүрдэл хэсэгт их засвар хийсэн бичилтийг техникийн баримт бичигт оруулахыг дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдэд хориглоно:</p> <p>(1) <a href="#">Даргын</a> хүлээн зөвшөөрөхүйц арга техник ашиглан задалсан, цэвэрлэсэн, үзлэг шалгалт хийсэн болон шаардлагатай засвар хийж угсарсан;</p> <p>(2) дараах <a href="#">тест хийсэн</a>:</p> <p>(i) ИНД-21-ийн дагуу олгосон маягийн гэрчилгээ, <a href="#">нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл бусад</a>, үйлдвэрлэлийн зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулж баримтжуулсан, <a href="#">Даргын</a> хүлээн зөвшөөрөхүйц хүчинтэй стандарт болон техникийн өгөгдлийн дагуу; эсхүл</p> <p>(ii) <a href="#">Даргын</a> баталсан бусад стандарт, эсхүл техникийн өгөгдлийн дагуу.</p>	<p>этгээд агаарын хөлөг, түүний их бие, хөдөлгүүр, сэнс, тоног төхөөрөмж, эд ангийн их засварын бүртгэл, бичилтийг техникийн баримтанд хийхийг хориглоно:</p> <p>1/ задаргаа, цэвэрлэгээ, үзлэг, шалгалт, засвар нь <a href="#">ИНЕГ</a>-ын даргаас хүлээн зөвшөөрсөн арга технологийн дагуу хийгдсэн ба буцаан угсрагдсан;</p> <p>2/ дараах <a href="#">байдлаар шалгагдсан</a>:</p> <p>2.1 ИНД-21-ийн дагуу маягийн гэрчилгээ, үйлдвэрлэлийн зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулсан, <a href="#">ИНЕГ</a>-аас хүлээн зөвшөөрсөн техникийн үзүүлэлтүүд болон стандартын дагуу; эсхүл</p> <p>2.2 <a href="#">ИНЕГ</a>-аас хүлээн зөвшөөрсөн бусад техникийн үзүүлэлтүүд болон стандартын дагуу.</p>	
<p><b>43.57. Нөөц</b></p>	<p><b>43.57. Жилийн ба 100 цагийн үзлэг шалгалт/ Annual and 100-hour inspections</b></p> <p>(a) ИНД-91-д шаардсан, жилийн ба 100 цагийн үзлэг шалгалтыг энэ дүрмийн Хавсралт Ж-д заасны дагуу хийнэ.</p>	
<p><b>43.59. Радио <a href="#">станцын</a> тест болон үзлэг шалгалт</b></p> <p>ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн радио <a href="#">станцын</a> үзлэг шалгалт хийх этгээд нь Хавсралт В-д заасан тест болон үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p><b>43.59. Радио <a href="#">тоноглолын</a> үзлэг шалгалт/Radio station tests and inspections</b></p> <p>(a) ИНД-91-д шаардсан, агаарын хөлгийн радио <a href="#">тоноглолын</a> үзлэг шалгалтыг энэ дүрмийн Хавсралт Б-д заасны дагуу хийнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b>43.61. Өндөр хэмжигч системийн тест болон үзлэг шалгалт</b></p> <p>ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн өндөр хэмжигч системийн үзлэг шалгалт хийх этгээд нь <a href="#">Хавсралт D-д заасан</a> тест болон үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p><b>43.61. Өндөр хэмжигч системийг шалгах/Altimeter system tests and inspections</b></p> <p>(a) ИНД-91-д шаардсан, агаарын хөлгийн нислэгийн өндөр хэмжигч системийг шалгах үзлэгийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу боловсруулсан, ИНЕГ-аас баталгаажуулсан ТҮ-ний хөтөлбөрийн дагуу шалгана.</p>	<p>-Хавсралт D-ийн шаардлага нэмэгдсэн</p>
<p><b>43.63. SSR транспондерийн тест болон үзлэг шалгалт</b></p> <p>ИНД-91-ээр шаардсан ажиглалтын транспондерийн үзлэг шалгалт хийх этгээд нь <a href="#">Хавсралт E-д заасан тест болон үзлэг шалгалтыг</a> хийж гүйцэтгэх үүрэгтэй.</p>	<p><b>43.63. Агаарын хөлгийн хариулагчийг шалгах/SSR transponder tests and inspections</b></p> <p>(a) ИНД-91-д шаардсанаар, агаарын хөлгийн хариулагчийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу боловсруулсан, ИНЕГ-аас баталгаажуулсан ТҮ-ний хөтөлбөрийн дагуу шалгана.</p>	<p>-Хавсралт E-ийн шаардлага нэмэгдсэн</p>
<p><b>43.65. ELT,AELS-ийн тест болон үзлэг шалгалт</b></p> <p>ИНД-91-ийн G Бүлгийн дагуу шаардсан ELT,эсхүл AELS-ийн тест болон үзлэг шалгалт хийх этгээд нь Хавсралт F-д заасан</p>	<p><b>43.65. Ослын байршил дамжуулагчийн үзлэг шалгалт / Emergency locator transmitter tests and inspections</b></p> <p>(a) ИНД-91-д шаардсан, ослын байршил дамжуулагчийг</p>	<p>-Хавсралт F-ийн шаардлага нэмэгдсэн</p>



<p>холбогдох тест болон үзлэг шалгалтыг хийх үүрэгтэй.</p>	<p>шалгах үзлэгийг энэ дүрмийн Хавсралт Е-д заасны дагуу гүйцэтгэнэ.</p>	
<p><b>43.67. Үл эвдэх сорил</b></p> <p>Холбогдох техник үйлчилгээний өгөгдөл нь шингэн нэвчүүлэх, соронзон бөөм, хуйларсан гүйдэл, хэт авиа, эсхүл радиографийн аргыг ашиглан үл эвдэх сорилын тест хийхийг шаардсан бол, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд нь:</p> <p>(1) тухайн ашиглаж байгаа арга техникт тохирсон, үзлэг шалгалтын ажилтныг гэрчилгээжүүлэх зөвлөлөөс (СВІР) олгосон гэрчилгээтэй, эсхүл түүнтэй дүйцэх, <a href="#">Даргын</a> хүлээн зөвшөөрөхүйц гэрчилгээ эзэмшдэг байна;</p> <p>(2) тухайн үл эвдэх сорилыг <a href="#">Даргын</a> хүлээн зөвшөөрөхүйц тохирох арга, техник болон практик аргачлал ашиглан хийнэ.</p>	<p><b>43.67. Үл эвдэх сорилын аргаар шалгах/Non-destructive testing</b></p> <p>(a) Агаарын хөлөг, түүний эд ангийн ТҮ-нд шингэний нэвчих арга, соронзон бөөмийн арга, хуйларсан гүйдлийн арга, хэт авианы болон радиографийн зэрэг үл эвдэх сорилын аргуудыг ашиглах бол тухайн ТҮ-г гүйцэтгэх этгээд нь:</p> <p>1/ ашиглаж буй техник технологид тохирсон, олон улсын байгууллагаас олгосон гэрчилгээ, эсхүл <a href="#">ИНЕГ</a>-аас хүлээн зөвшөөрсөн адил чанарын гэрчилгээтэй байна;</p> <p>2/ <a href="#">ИНЕГ</a>-аас хүлээн зөвшөөрсөн үл эвдэх сорилын аргын зохих аргачлал, техник технологийг ашиглан гүйцэтгэнэ.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p><b><u>43.69. Техник үйлчилгээний бүртгэл хөтлөх</u></b></p> <p>(a) <a href="#">Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээ хийх этгээд нь тухайн техник үйлчилгээ дууссаны дараа, дараах мэдээллийг зохих MLB-т оруулах үүрэгтэй:</a></p> <p>(1) <a href="#">хэрэв хамааралтай бол, техник үйлчилгээний дараах дэлгэрэнгүй мэдээлэл:</a></p> <p>(i) <a href="#">хийсэн үзлэг шалгалтын таних тодорхойлолтыг;</a></p> <p>(ii) <a href="#">тухайн гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг;</a></p> <p>(iii) <a href="#">тухайн ашигласан техникийн өгөгдлийг;</a></p> <p>(iv) <a href="#">хэрэв тухайн техник үйлчилгээ нь 43.103(a)(4)-ийн дагуу нислэгийн шалгалт шаарддаг бол, тухайн үйл ажиллагааны нислэгийн шалгалтын шаардлагыг;</a></p> <p>(2) <a href="#">хэрэв тухайн техник үйлчилгээний үед бүрдэл хэсгийг салгасан, эсхүл суурилүүлсан бол:</a></p> <p>(i) <a href="#">тухайн бүрдэл хэсгийн тодорхойлолтыг;</a></p> <p>(ii) <a href="#">түүний эд ангийн дугаар болон серийн дугаарыг, хэрэв байгаа бол;</a></p> <p>(iii) <a href="#">холбогдох шилжүүлэх баримт бичгийн ишлэлийг;</a></p> <p>(3) <a href="#">тухайн техник үйлчилгээний хүрээнд газарт, эсхүл агаарт хийсэн төстийн үр дүнг багтаасан хэмжилт, эсхүл төстийн үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг;</a></p> <p>(4) <a href="#">өндөр хэмжигч системийн тест болон үзлэг шалгалтын хувьд, тухайн өндөр хэмжигчид тест хийсэн огноо болон максимум түвшнийг;</a></p>	<p><b>43.69 Техник үйлчилгээний бичиг баримтын хөтлөлт/Maintenance records</b></p> <p>(a) Агаарын хөлөг, түүний эд ангид ТҮ хийсэн аливаа этгээд уг ТҮ-ний ажил дууссаны дараа бичиг баримтын дараах хөтлөлтийг хийнэ:</p> <p>1/ үзлэг шалгалт хийхэд ашигласан заавар, технологи ба ТҮ-гээр хийгдсэн нийт ажилд болон техникийн үзүүлэлт;</p> <p>2/ буусан, суурилуулсан эд ангийн:</p> <p>2.1 тодорхойлолт;</p> <p>2.2 үйлдвэрлэгчийн болон серийн дугаар;</p> <p>2.3 "ИНЕГ-ын Маягт нэг"-ийн тайлбар, эсхүл ТҮ-нээс гаргасан баримт.</p> <p>3/ хийсэн ТҮ-ний ажил, үзлэг шалгалтын үр дүн, газарт болон агаарт шалгасан дүгнэлт;</p> <p>4/ өндөр хэмжигч системийн үзлэг шалгалт, шалгагдсан</p>	<p>-Орчуулга, найруулга зассан</p> <p>-Amend.5-аар өөрчлөгдсөн</p>

- (5) хэрэв AD-ийг тухайн техник үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлсэн бол:
- (i) тухайн AD дугаарыг;
  - (ii) тухайн өөрчлөлтийн огноог;
  - (iii) тухайн хэрэгжүүлэлтийн хэлбэрийг;
- (6) тухайн байрлал болон хэрэв хамааралтай бол, техник үйлчилгээг гүйцэтгэсэн байгууламжийн нэрийг;
- (7) тухайн техник үйлчилгээг хийх болсон шалтгааныг.

(b) Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээ хийх этгээд нь дараах тохиолдолд, тухайн техник үйлчилгээний бүртгэл хийх зорилгоор холбогдох WS-ийг ашиглаж болно, хэрэв:

- (1) хийгдсэн техник үйлчилгээний нэгтгэсэн мэдээллийг зохих MLB-д бичиж оруулсан бол;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ийн дагуу шаардсан техник үйлчилгээний нэгтгэсэн мэдээлэлд тухайн WS-ийг иш татсан бол.

(c) Агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх этгээд нь TLB-д бичиж оруулсан гэмтлийг арилгах, эсхүл TLB-д бичиж оруулсан үзлэг шалгалтыг хийсний дараа:

- (1) тухайн техник үйлчилгээний гүйцэтгэлийг TLB-д бүртгэх;
- (2) энэ зүйлийн (a)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг зохих MLB-д бүртгэх; эсхүл
- (3) хэрэв MLB бэлэн байхгүй бол тухайн техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг техник үйлчилгээ хийсэн агаарын хөлгөөр тээвэрлэхээс бусад, өөр боломжит аргаар MLB хадгалагдаж байгаа газарт хүргэх үүрэгтэй.

(d) Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийсэн этгээд нь энэ зүйлийн (a), (b), (c)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэсний дараа, техник үйлчилгээний бүртгэлд дараах мэдээллийг оруулах үүрэгтэй:

- (1) тухайн этгээдийн нэр;
- (2) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;
- (3) хэрэв хамааралтай бол, тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;

өндрийн хамгийн их хэмжээ, огноо;

5/ дууссан огноо;

6/ ТҮ хийсэн этгээдийн, эсхүл ТҮ-нээс гаргасан эрх бүхий этгээдийн нэр;

7/ ТҮ-г хийсэн байгууллагын нэр, хаяг;

8/ ТҮ хийгдэх болсон шалтгаан (хатуу буулт, эсхүл зөрчил, дутагдлын улмаас үүссэн эвдрэл гэмтэл, дутагдал гэх мэт).

(б) ТҮ хийх этгээд нь:

1/ хөлгийн борт журнал болон ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн ТҮ-ний бичиг баримтад энэ зүйлийн (a)-д заасан бичилтийг хийнэ;

2/ бичиг баримтын хөтлөлтийг тод гаргацтай бичнэ;

3/ дараах бичиг баримтад ТҮ-ний ажлын карт-наряд болон холбогдох бусад зүйлийг лавлах болгон тэмдэглэнэ:

3.1 борт журнал;

3.2 ИНЕГ-ын хүлээн зөвшөөрсөн ТҮ-ний баримт бичиг.

-Amend.5-аар өөрчлөгдсөн

<p>(4) <u>тухайн техник үйлчилгээг хийж дууссан огноо.</u></p> <p>(e) <u>ИНД-91.509(b)-д шаардсаны дагуу, ашиглалтын цаг бүртгэгчээр тоногдсон агаарын хөлөгт хуваарьт техник үйлчилгээ хийх этгээд нь тухайн техник үйлчилгээг хийж дууссаны дараа, дараах мэдээллийг зохих MLB-д бичиж оруулах үүрэгтэй:</u></p> <p>(1) <u>тухайн ашиглалтын цаг бүртгэгчийн нийт заалтыг;</u></p> <p>(2) <u>ашиглалтын цаг бүртгэгчийг сүүлчийн хуваарьт үзлэг шалгалтаас хойш оролдож өөрчилсөн байж болох шинж тэмдгийг.</u></p> <p>(f) <u>Тухайн техник үйлчилгээг гүйцэтгэсэн дэлгэрэнгүй мэдээллийг энэ зүйлийн (a) (e)-д шаардсан этгээд нь бэхээр алдаагүй, тод гаргацтай, эсхүл байнгын арилдаггүй бусад байдлаар бүртгэх үүрэгтэй.</u></p>		
<p><b>С Бүлэг-Ашиглалтад шилжүүлэх</b></p>	<p><b>В БҮЛЭГ. <u>ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ГАРГАХ</u>/RELEASE TO SERVICE</b></p>	<p>Release to service- “Ашиглалтад шилжүүлэх”</p>
<p><b>43.101. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд</b></p> <p>(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (c) болон 43.54-ийг харгалзан, дараах шаардлагыг хангаагүй этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:</p> <p>(1) ИНД-66-гийн дагуу олгосон тохирох <u>категори</u> болон зэрэглэл бүхий хүчинтэй AMEL эзэмшдэг байх; эсхүл</p> <p>(2) Хамааралгүй</p> <p>(3) ИНД-145-ын дагуу олгосон тохирох ангилал бүхий агаарын хөлгийн ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс, тухайн агаарын хөлөг, эсхүл эд ангийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх зөвшөөрөлтэй байх; эсхүл</p> <p>(4) ИНД-66-гийн дагуу олгосон, зохих баталгаажуулсан тэмдэглэл бүхий хүчинтэй <u>МАС</u> эзэмшдэг байх; эсхүл</p> <p>(5) Монгол Улсын гадна хийсэн техник үйлчилгээний хувьд, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрхийн хүрээнд олгосон, <u>Даргын</u> хүлээн зөвшөөрөхүйц, тухайн маягийн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн зохих хүчинтэй <u>AMEL</u>, эсхүл зөвшөөрөл эзэмшдэг байх; эсхүл</p> <p>(6) <u>тухайн техник үйлчилгээг 43.51(b)-гийн дагуу хийсэн</u></p>	<p><b>43.101 Агаарын хөлөг, түүний эд ангийг техник үйлчилгээнээс гаргах эрх / Persons to certify release-to-service</b></p> <p>(a) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд дараах шаардлагыг хангасан этгээд агаарын хөлөг, түүний эд ангийг ТҮ-нээс гаргах эрхтэй:</p> <p>1/ ИНД-66-ын дагуу, агаарын хөлгийн ТҮ-ний ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, холбогдох маягийн зэрэглэлтэй; эсхүл</p> <p>2/ <u>ИНД-145-ын дагуу гэрчилгээ эзэмшигч байгууллагаас ТҮ-г баталгаажуулах эрх олгогдсон, эсхүл</u></p> <p>3/ <u>ИНЕГ</u>-аас олгосон мэргэжлийн үнэмлэхэнд агаарын хөлөг, түүний эд анги тоног төхөөрөмжийг ТҮ-нээс гаргах эрхийн тэмдэглэгээ хийгдсэн байна;</p> <p>4/ нисэгчийн үнэмлэх эзэмшигч этгээд нь ТҮ-г энэ дүрмийн 43.51-ийн (б)-ийн дагуу гүйцэтгэнэ;</p> <p>5/ агаарын хөлөг, эсхүл түүний эд ангийн техник үйлчилгээ Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна хийгдэх бол тухайн ТҮ-г гүйцэтгэх этгээд нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг улсын эрх бүхий байгууллагаас олгосон мэргэжлийн үнэмлэхтэй байна.</p>	

<p><u>байх.</u></p> <p>(b) <u>Хэрэв глайдерын байгууллагаас глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрхийг тухайн этгээдэд олгосон бол, глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно.</u></p> <p>(c) <u>Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээг хийх, хянах, эсхүл гэрчилгээжүүлэх ажлаас дараах байдлаар чөлөөлөгдөж амарснаас бусад тохиолдолд аливаа этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:</u></p> <p>(1) <u>ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийн өмнөх 24 цагийн хугацаанд үргэлжилсэн 8-аас доошгүй цаг амарсан;</u></p> <p>(2) <u>ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийн өмнөх 30 хоногийн хугацаанд үргэлжилсэн 24 цагаас доошгүй хугацаагаар, 4-өөс доошгүй удаа амарсан.</u></p>	<p>(б) Аливаа этгээд ИНД-149-д заасны дагуу планер болон түүний эд ангийн ТҮ-г баталгаажуулах зөвшөөрөлтэй бол планер, түүний эд ангид ТҮ хийгдсэний дараа тэдгээрийг ТҮ-нээс гаргаж болно.</p>	<p>-Amend.5-өөр өөрчлөгдсөн</p>
<p><b><u>43.103. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх шаардлага</u></b></p> <p>(a) <u>Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхгүй:</u></p> <p>(1) <u>тухайн техник үйлчилгээг энэ Дүрмийн шаардлагын дагуу хийсэн бол;</u></p> <p>(2) <u>тухайн этгээд нь 43.101–ийн шаардлагыг хангасан бол;</u></p> <p>(3) <u>тухайн техник үйлчилгээний хувьд агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь ашиглалтад шилжүүлэхэд тохирч байгаа бол;</u></p> <p>(4) <u>хэрэв агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлт, эсхүл үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлж болох техник үйлчилгээг тухайн агаарын хөлөгт хийсэн бол:</u></p> <p>(i) <u>ИНД-91.613-ын дагуу шаардлага хангасан үйл ажиллагааны нислэгийн шалгалтыг гүйцэтгэсэн ба нислэгийн шалгалтын гүйцэтгэлийг агаарын хөлгийн MLB-д, эсхүл WS болон TLB-д бичиж оруулсан байх; эсхүл</u></p> <p>(ii) <u>газрын тест, үзлэг шалгалт, эсхүл аль аль нь агаарын хөлгийн нислэгийн шинж чанарыг мэдэгдэхүйц өөрчлөөгүй, эсхүл нислэгийн үйл ажиллагаанд их хэмжээгээр нөлөөлөөгүй болохыг тодорхой харуулсан.</u></p>	<p><b>43.103. ТҮ-нээс гаргахад тавигдах шаардлагууд / Requirements for certifying release-to-service</b></p> <p>(a) Шаардлага хангаагүй, эсхүл ТҮ нь холбогдох дүрмийн дагуу гүйцэтгэгдээгүй агаарын хөлөг, түүний эд ангийг ТҮ-нээс гаргахыг хориглоно.</p>	<p>-Орчуулга, найруулга зассан.</p> <p>-“ТҮ-ээс гаргах” гэснийг “Ашиглалтад шилжүүлэх” гэж өөрчилөгдсөн</p> <p>-Amend.5-аар өөрчлөгдсөн</p>

газарт хийсэн тест болон үзлэг шалгалтын дэлгэрэнгүй мэдээллийг тухайн агаарын хөлгийн MLB-д, эсхүл WS-д бичиж оруулсан байх; эсхүл

(iii) энэ зүйлийн (a)(4)(i)-ийн дагуу шаардсан үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор ашиглалтад шилжүүлсэн байх.

(b) Дараахаас бусад тохиолдолд аливаа этгээд том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засвар хийсний дараа, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхгүй:

(1) тухайн этгээд нь 43.101-ийн шаардлагыг хангасан байх;

(2) тухайн том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засвар нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлтэй нийцсэнийг E Бүлгийн дагуу гэрчилгээжүүлсэн байх;

(3) тухайн том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын хувьд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь ашиглалтад шилжүүлэхэд тохирч байх;

(4) хэрэв энэ зүйлийн (b)(2)-ын дагуу хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөл нь тухайн нислэгийн зааврын үйл ажиллагааны хязгаарлалт, эсхүл нислэгийн өгөгдлийн өөрчлөлтийг агуулдаг бол, тухайн өөрчлөлтийг нислэгийн зааварт тусгасан байх.

(c) Энэ зүйлийн (a)(4)(iii)-ын дагуу үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх үүрэг бүхий этгээд нь тухайн агаарын хөлгийн MLB, эсхүл WS болон TLB-д дараах мэдээллийг бичиж оруулах үүрэгтэй:

(1) ашиглалтад шилжүүлэх дараах мэдэгдэл:

“Бүртгэгдсэн ажлын хүрээнд тухайн агаарын хөлгийг зөвхөн үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор ашиглалтад шилжүүлэв”;

(2) ашиглалтад шилжүүлэх мэдэгдлийн дараа:

(i) тухайн этгээдийн нэр;

(ii) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;

(iii) тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;

(iv) тухайн бүртгэлийг оруулсан огноо.

(б) Агаарын хөлөг, түүний эд ангид хийгдсэн үндсэн өөрчлөлт, үндсэн засвар нь энэ дүрмийн "Д" Бүлэгт заагдсаны дагуу баталгаажаагүй тохиолдолд тэдгээрийг ТҮ-нээс гаргахыг хориглоно.

(в) Агаарын хөлөг, түүний эд ангийн өөрчлөлт, эсвэл засварын үеийн техникийн үзүүлэлтүүд нь Нислэг ашиглалтын зааварт тусгагдсан нислэгийн үзүүлэлтүүд ба ашиглалтын хязгаарлалтуудыг өөрчлөхөд хүрвэл тухайн өөрчлөлтүүдийг Нислэг ашиглалтын зааварт оруулах хүртэл агаарын хөлөг, түүний эд ангийг ТҮ-нээс гаргахыг хориглоно.

(г) 10 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд тухайн маягийн агаарын хөлгийг хүйтний улиралд ашиглах тухай Иргэний нисэхийн ерөнхий газраас хүлээн зөвшөөрсөн журмын заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд бүх төрлийн техник үйлчилгээнээс (нислэгийн өмнөх болон завсрын буудалд гүйцэтгэх техник үйлчилгээг оролцуулаад) гаргахыг хориглоно.

**43.105. Техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь зохих **MLB, эсхүл WS болон шаардлагатай бол, TLB-д** 43.69-ийн дагуу бүртгэгдсэн байхыг шаардсан техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг дараах мэдээллийн хамт бүртгэх үүрэгтэй:

(1) тухайн этгээдийн нэр;

(2) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;

(3) тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;

(4) тухайн бүртгэлийг оруулсан огноо;

(5) ашиглалтад шилжүүлэх дараах мэдэгдэл, хэрэв MLB, WS, эсхүл TLB-д тогтсон хэлбэртэй дүйцэх мэдэгдэл байдаггүй бол;

“Бүртгэгдсэн техник үйлчилгээг ИНД-43-ын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэсэн ба энэхүү техник үйлчилгээний хүрээнд тухайн (агаарын хөлөг)\* (бүрдэл хэсэг)\*-ийг ашиглалтад шилжүүлэв.”

\* - хамааралгүйг үстгах

(b) Хэрэв бүрдэл хэсэг нь агаарын хөлөгт суурилагаагүй, эсхүл суурилуулахаар хуваарилаагүй бол, тухайн бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь дараах маягтын дагуу ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх үүрэгтэй:

(1) дараах тохиолдолд CAA Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ, хэрэв:

(i) тухайн техник үйлчилгээг ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд хийхийг 43.54-т шаардсан бол; эсхүл

(ii) тухайн бүрдэл хэсгийг ИНД-148-ын дагуу олгосон

**43.105. Техник үйлчилгээний дараах баталгаажуулалт / Certifying release-to-service after maintenance**

(a) Агаарын хөлөг, түүний эд ангийг ТҮ-нээс гаргах эрх бүхий этгээд агаарын хөлгийн **бортжурнал болон бусад бичиг баримтад** энэ дүрмийн 43.69-ийн (б)-гийн 1/-д шаардсаны дагуу тэмдэглэл хийхдээ:

1/ ТҮ-нээс гаргах баталгааг:

1.1 энэ дүрмийн 43.69-т шаардсан бичилтүүд хийгдсэний дараа;

1.2 ТҮ-ний ажил нь холбогдох дүрмийн дагуу хийгдэж ТҮ-нээс гаргах шаардлагад нийцсэнийг бататгасны дараа тус тус гаргана.

2/ ТҮ-нээс гаргах баталгаанд:

2.1 баталгаа гаргасан этгээдийн гарын үсэг, үнэмлэх / зөвшөөрлийн дугаар;

2.2 баталгаа гаргасан он, сар, өдрийг бичнэ.

